



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/Б44

Хэрлэн сум

Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг
зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 03-ны 10 тоот тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх зорилтын хүрээнд Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сумдад нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, шинжилгээг зохион байгуулахад 5,123,680 (таван сая нэг зуун хорин гурван мянга зургаан зуун наяд) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Үйл ажиллагааг өндөр түвшинд зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр)-д, зорилтот насны хүн амыг бүрэн хамруулж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үзлэг, шинжилгээнд зарцуулагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022
оны 10 дугаар сарын 27-ны
дугаар захирамжийн хавсралт

ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Бүгд үнэ
1	Томилолт	49,030	8 хоног, 5 хүн	1,961,200
2	Шатахууны зардал	Дизель 2560 л, 100 км-т 20 л	415 км	212,480
3	Тэмбүүгийн тест	2400	700 ш	1,680,000
4	ДОХ-ын оношлуур	300 хүн тун	2,400 ш	720,000
5	Бээлий	900	500 хос	450,000
6	Баннер	2x3	-	100,000
7	Нийт дүн			5,123,680